



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/215

Номгон

Коронавирусын халдварын тархалтын
түвшинг “Улбар шар” түвшинд шилжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “б”, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Коронавируст халдварын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын 2.1.2, 4.3, аймгийн Засаг даргын 2021 оны А/02, А/119 дүгээр захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 28 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдварын тохиолдол тус аймагт илэрч, батлагдсантай холбогдуулан иргэд, олон нийтийг цар тахлын халдварын аюулаас хамгаалах зорилгоор аймгийн хэмжээнд халдварын тархалтын түвшинг “Улбар шар” түвшинд шилжүүлсүгэй.

2.Халдварын тархалтын “Улбар шар” түвшинд шилжсэнтэй холбогдуулан дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.

2.1.Аймгийн төв рүү орох, гарах хөдөлгөөнийг 7 хоногийн хугацаатай хязгаарлаж, тус аймгаас Улаанбаатар хот руу зорчих иргэдийг нийслэлийн Онцгой комиссын зөвшөөрлөөр, Улаанбаатар хотоос тус аймагт зорчих иргэдийг аймгийн Онцгой комиссын зөвшөөрлөөр, аймаг дотор (өөрийн сум хооронд) зорчих иргэдийг сумын Онцгой комиссын зөвшөөрлөөр тус тус нэвтрүүлэх, шаардлагагүй тохиолдолд Улаанбаатар хотоос иргэдийг татан авахгүй байхыг Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, (Цагдаагийн хурандаа Б.Оюутболд)-д;

2.2.Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудлуудыг “Тусгаарлах байр”-аар дайчлан ажиллуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн (М.Өнөржаргал)-д;

1010539

2.

2.3.Баянхонгор, Баянговь, Жаргалант сумдын ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 7 хоногийн хугацаагаар түр хугацаагаар зогсоохыг Баянхонгор, Баянговь, Жаргалант сумдын Засаг дарга нарт, бусад сумдын ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг тухайн сумдын Онцгой комиссын шийдвэрээр;

2.4.Архи, согтууруулах ундааны зүйлээр үйлчилдэг баар, ресторан, караокены үйл ажиллагааг тодорхойгүй хугацаагаар зогсоож, зарим зохион байгуулалтын арга хэмжээг сумын Онцгой комиссын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж ажиллахыг;


2.5.Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллага, банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг ажлын өдрүүдэд 10:00-15:00 цагийн хооронд явуулж, ажлын тусгай горимд шилжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт;

2.6.Халдварын тархалтын тандалт, судалгааг шуурхай зохион байгуулж сэжигтэй тохиолдлын ойрын 1, 2 дугаар хавьтлуудыг илрүүлэх ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал), Цагдаагийн газар (Б.Оюутболд), Тагнуулын хэлтэс (Дэд хурандаа Р.Мэндбаяр);

2.7.Коронавируст халдварын тохиолдол батлагдсантай холбогдуулан халдвар авсан иргэнийг тусгаарлах эмнэлэгт байрлуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн (Н.Энхжаргал)-д;

2.8.Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын үйл ажиллагааг эрчимжүүлж, хяналт тавьж ажиллахыг Шуурхай штабын дарга (дэд хурандаа Э.Батбаярт)-д тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН